



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/130

Арвайхээр

**Барилга байгууламжийг ашиглалтад оруулах
комиссын бүрэлдэхүүн томилох тухай**


Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны Дүрэм шинэчлэн батлах тухай 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс, Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс, Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчилэн баталсугай.

2. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Батжаргал)-д, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ч.Гүнсэнхорол)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан “Комиссын бүрэлдэхүүн томилох тухай” аймгийн Засаг даргын 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн А/409 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100294